

**НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН  
ӨМЧИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН  
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

2025 оны 05 дугаар сарын 29

Улаанбаатар хот

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэт гэлийн хувь
1	2	3	4	5	6		

**Зорилго 1. Хөгжлийн бодлогын барим бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллана.**

Зорилт 1. Нийслэлийн орлого, санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, төсвийн хөрөнгийг эдийн засаг, нийгмийн хөгжилд чиглүүлсэн, үр ашигтай, хариуцлагатай төлөвлөж, сахилга батыг сайжруулна.

1.	Арга хэмжээ 2.13 Нийслэлийн өмчийн эд хөрөнгийг иргэн, хуулийн этгээдэд түрээслэх түрээслэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн комисст орж ажиллах <sup>2.13</sup>	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	10 100%	10 100%	<p>Газрын даргын 2025 оны, А/05, А/07, А/34, А/35, А/39, А/52, А/58, А/678 дугаар тушаалаар байгуулагдсан 8 удаагийн сонгон шалгаруулалтын ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж санал хүргэн ажилласан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- “Өргөө амаржих” газрын цайны газрын түрээсийн сонгон шалгаруулалт</li> <li>- Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газрын байранд цайны газрын түрээсийн сонгон шалгаруулалт</li> <li>- Хүрээ амаржих газрын гадна 30 автомашины зогсоолын түрээсийн сонгон шалгаруулалт</li> <li>- Баянгол дүүргийн Эрүүл мэндийн төвийн төв буфетын түрээсийн сонгон шалгаруулалт</li> <li>- Налайх дүүргийн Боловсрол сургуулийн цайны газрын түрээсийн сонгон шалгаруулалт</li> <li>- Нийслэлийн тээврийн газрын Шархадны эцсийн буудлын барилгад-2 байр талбай,</li> <li>- Улайстайн эцсийн буудлын барилгын 3 талбай</li> <li>- Нийслэлийн нутгийн захиргааны цогцолбор барилгын Б блок байрны 1 давхрын “Сүлжээ дэлгүүр”</li> </ul>	100%
----	---	---	-----------------------------------	------------	------------	--	------

						- "Гэрлэх ёслолын ордон" ОНӨААТҮГ-ын 1 давхарт байрлах "Кофе шоп"	
2.	Арга хэмжээ 2.19 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний эрх шилжүүлсэн ажилд захиалагчийн хяналт тавих, захиалагчийн хяналт тавьсан төсөл, арга хэмжээний 5%- ийн барьцаа хөрөнгийг чөлөөлөх	-	Санхүүжилтийн дүн, сая төгрөг	Захиалагчийн хяналт 33.2 Барьцаа чөлөөлөх 17.8	Эрх шилжүүлсэн ажлын захиалагчийн хяналтыг тавьж хөрөнгө хүлээлгэн өгч, санхүүжилтий г олгосон байна. Ашиглагч байгууллагын хүснэгтийн дагуу барьцаа хөрөнгө чөлөөлсөн байна.	<p>Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгө хүлээж авах дараах ажлын хэсгүүдэд ажилласан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- "Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар" ОНӨААТҮГ-ын даргын 2024.12.09 өдрийн А/175 тушаалаар Сонгинохайрхан дүүргийн хороодод иж бүрэн компьютер хүлээлцэх ажил,</li> <li>- Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2024.12.16-ны өдрийн А/192 дугаар тушаалаар Төв цэнгэлдэх хүрээлэнд авто зогсоол шинээр байгуулах ажлыг байнгын ашиглалтад хүлээж авах ажил,</li> <li>- Монгол Улсын Эрчим хүчиний сайдын 2024.12.17-ны өдрийн А/290 тушаалаар Улаанбаатар хотын Багануур дүүрэгт 220/110/35 кВ-ын "Багануур" дэд станцын 110 кВ-ын хувиарилах байгууламжийн өргөтгөл, 110 кВ-ын 2 хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугам, 110/35 кВ-ын станц, 50 МВт-ын хүчин чадалтай 200 МВт.ц-ийн багтаамж бүхий эрчим хүч хуримтлуурын станцын барилга угсралт хүлээн авах ажил,</li> <li>- Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ-ын даргын 2025. 01.10-ны өдрийн "Ажлын хэсэг байгуулах тухай" А/189 дүгээр тушаалаар СХД-ийн ЗДТГ-т "Төрийн байгууллагуудын цахим тоног, төхөөрөмж" хүлээлцэх ажил, гэрээний дүн – 88,998,000 төгрөг</li> <li>- Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ-ын даргын 2025.03.12-ны өдрийн А/24 дүгээр тушаалаар НЗД-ын 2024.12.26-ны өдрийн А/1338 дугаар захирамж, НХААГ/20240102676, дугаартай ажлын НХААГ/20240102677 гэрээний дагуу "Эмнэлгийн тоног төхөөрөмж", ажил, Гэрээний дүн – 100,996,000 төгрөг, 23,788,000 төгрөг</li> <li>- Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ-ын даргын 2025 оны</li> <li>- .....тушаалын дагуу "Нумт-Өргөө" ХХК-ийн НХААГ /20240102554/ гэрээний дагуу нийлүүлж байгаа тоног төхөөрөмжүүдийг хүлээн авах ажил</li> </ul>	100%

						<p>- Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ-ын даргын 2025 оны А/95 дугаар тушаалаар томилогдсон “Хөрөнгө худалдан авах” ажлын хэсгийн хуралд санал, дүгнэлтийг өгсөн.</p> <p>- НИТХ-ын 2025.03.28-ны өдрийн 25/58 дугаар тогтоолоор нийслэлийн өмчид иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас үнэ төлбөргүй шижлуулж буй нийт 2,442,061,654 төгрөгийн үнэ бүхий орон сууцны инженерийн шугам сүлжээ бүртгэх НЗД-ын захирамжийн төсөлд санал авсан.</p>	
3.	Арга хэмжээ 2.20 Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгийн хөдөлгөөний асуудлыг “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын хуралд оролцон хяналт тавих	-	Хурлын тоо	4	10	“Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 1 удаагийн хуралд оролцон санал хүргэн хяналт тавьж ажилласан.	100%
4.	Арга хэмжээ 2.23 Нийслэлийн Засаг даргын захирамжаар нийслэлийн өмчит хуулийн этгээдийн данснаас хассан тээврийн хэрэгслийн нээлттэй дуудлага худалдаанд оролцох, хяналт тавих	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	-	50%	Нийслэлийн Засаг даргын захирамжаар нийслэлийн өмчит хуулийн этгээдийн данснаас хассан тээврийн хэрэгслийн нээлттэй дуудлага худалдаа зарлагдаагүй, ажлын хэсэг байгуулагдаагүй байна.	-

5.	Арга хэмжээ 2.29 Холбогдох хууль тогтоомжийн төсөлд санал оруулах, өмчтэй холбоотой хууль, дүрэм, журмыг сурталчлан, арга зүйгээр хангах	-	Саналын тоо Хэрэгжилтийн хувь	5 100%	50%	<p>Шинэ буюу шинэчилсэн найруулгын 6 хуулийн төсөлтэй танилцсан.</p> <p>“Төрийн болон орон нутгийн өмчтэй компанийн тухай” хуулийн төсөл, “Нийтийн өмчийн тухай” хуулийн төсөлд санал хүргүүлэн, шинэчлэгдсэн хуулиуд батлагдсаны дараа нийслэлийн өмчтэй холбоотой мөрдөж буй журмыг хуульд нийцүүлэн шинэчлэн боловсруулж өргөн барихаар ажиллаж байна.</p>	100%
6.	Арга хэмжээ 2.31 Нийслэлийн өмчийг эзэмшин үйл ажиллагаа явуулж байгаа аливаа хуулийн этгээдийн өмчийн эзэмшилт, өөрчлөлт, захиран зарцуулалт, ашиглалтад эрх хэмжээнийхээ хүрээнд хяналт шалгалт хийх төлөвлөгөө батлан хэрэгжилтийг ханган ажиллах	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	100%	100%	<p>Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 55 дугаар тогтоолоор баталсан “Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ байгуулах, гэрээний биелэлтийг дүгнэх журам”, 65 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журам”, нийслэлийн Засаг даргын 2023 оны А/727 дугаар захирамжаар баталсан “Нийслэлийн нутгийн захирагааны байгууллагуудын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт зохион байгуулах журам”-ын дагуу нийслэлийн өмчийг эзэмшин үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудын өмчийн эзэмшилт, өөрчлөлт, захиран зарцуулалт, ашиглалтад эрх хэмжээнийхээ хүрээнд хяналт шалгалт хийлээ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- НӨХХГ-ын даргын 2024.12.31-ний өдрийн А/798 дугаар тушаалаар 6 дүүрэгт нийт 112 барилга, байгууламжийн сул буюу илүүдэлтэй байр талбай, түрээсийн гэрээний хэрэгжилтийг шалгаж танилцуулсан. /Ажлын хэсгийн тайланг хавсаргав/.</li> <li>- НӨХХГ-ын даргын 2025 оны А/40 дүгээр тушаалаар 6 дүүргийн 220 барилга байгууламж, Эрүүл мэндийн төв, ΘЭМТ-ийн байр ашиглалт, түрээсийн гэрээний хэрэгжилт, төлбөр төлөлгүй нийслэлийн өмчийг ашиглан үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, хуулийн этгээдийг олж тогтоох, гэрээ байгуулахыг даалгах, байр талбайг чөлөөлүүлэх, түрээсийн төлбөрийг нийслэлийн төсөөвт төвлөрүүлсэн эсэхийг газар дээр нь шалгаж,</li> </ul>	100%

					<p>зөрчлийг арилгах зөвлөмж өгч ажилласан./Ажлын хэсгийн тайланг хавсаргае./</p> <ul style="list-style-type: none"> <li>- НӨХХГ-ын даргын 2025 оны А/62 удирдамжийн дагуу 6 дүүргийн ЗДТГ,ИХ, Боловсролын нийт 375 байгууллагын 434 барилга байгууламжийг газар дээр нь очиж үзэн, хяналт шалгалтыг хийж, түрээсийн гэрээгээр үйл ажиллагаа явуулж байгаа байр талбайд хяналтын хэмжилт хийх, барилгын дээвэр дээр үүрэн телефоны станц антен, байр талбайд бэлэн мөнгөний ATM, киоск машинуудыг байршуулсан эсэхэд хяналт шалгалт хийн зөвлөмж өгч ажилласан. Хяналт шалгалтын тайлан НЗД-ын зөвлөлийн хуралд танилцуулсан, цаашид авах арга хэмжээг хурлын тэмдэглэлээр үүрэгжүүлэв.</li> </ul> <p>Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Нийслэлийн Төр Захиргааны 5 дугаар байранд байрлах нийслэлийн харьяа 4 байгууллагын байр ашиглалт, Ашигтт малтмалын газрын Цөмийн болон цацрагийн хэлтэс, БГД-т байрлах МШ-ийн 24-р салбарын гар утасны түрээслэгчид, Ачит гар ӨЭМТ-д байр талбай чөлөөлөх талаар мэдэгдэл хүргүүлэв.</li> <li>- СХД-н Цагдаагийн гуравдугаар хэлтэст “Уламжлалт анагаах ухааны элэг судлалын клиник төө”-ийн холбогдох баримт бичгийн хуулбар, лавлагааг нотлох баримтын шаардлагыг хангуйж хүргүүлсэн.</li> <li>- Соёлын Төв өргөөний Г блокд байрлах нийслэлийн харьяа 6 байгууллага, 24 иргэн, аж ахуй нэгжийн 150 гаруй өрөө үйл ажиллагаа явуулж байснаас 30 иргэн аж ахуй нэгжид байр талбай чөлөөлөх тухай мэдэгдэх хуудсыг 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрөөс 01 дүгээр сарын 08-ны өдрийн хооронд хүргүүлж, сүл байр талбайн ашиглалтыг илтгэх хуудсаар танилцуулсан.</li> <li>- СБД-ийн 11 дүгээр хорооны Барилгачидын гудамжид барилгын хашаан дотор 2012, 2013</li> </ul>	
--	--	--	--	--	---	--

					<p>байршуулсан сурталчилгааны самбарын талаар хорооны ажилтан, барилга барихаар төлөвлөсөн компаниас мэдээллийг авч удирдлагад танилцуулсан.</p> <ul style="list-style-type: none"> <li>- “Уламжлалт анагаах ухааны элэг судлалын клиник төв”-ийн СХД-т байрлах эмнэлэг, ХУД-т байрлах “Богд уул” Сувилалын хөрөнгийг СХД-ийн Нэгдсэн эмнэлгийн баг бүрэлдэхүүнтэй хамтран газар дээр нь очиж, хөрөнгийг тоолж, хүлээлцүүлсэн.</li> <li>- СТӨ-ны 8 дугаар давхрын 2 өрөө, Хүүхдийн номын сангийн 1 дааехрын 1 өрөөг ашиглаж байсан “Сөүлийн соёл мэдээллийн төв”-ийн байр талбайг чөлөөлүүлэн, үйл ажиллагаандaa ашиглаж байсан гэх тавилга, эд хогшил, тоног төхөөрөмжийг нийслэлийн өмчид бүртгэх, ашиглах боломжгүй талаар НЗДТГ-т албан бичгийг хүргүүлсэн.</li> <li>- Таван толгой түлш ХХК-д НӨХГ-ийн эзэмшил газарт шахмал түлшний агуулахын зориулалтаар баригдсан 59 саравчийг нийслэлийн өмчид бүртгэх, цаашид ашиглах боломжгүй, ашиглаж байсан газрын төлбөр тооцоог барагдуулан, газрыг чөлөөлж, манай байгууллагад хүлээлгэн өгөх тухай албан бичгийг хүргүүлсэн.</li> <li>- 9 дүүргийн харьяа нийслэлийн өмчимт хуулийн этгээдүүдийн ашиглалтын шаардлага хангахгүй байгаа барилга байгууламжуудын судалгааг авч нэгтгэн, газрын даргад танилцуулсан.</li> <li>- НӨХГ-ын даргын 2025 оны А/85 дугаар тушаалаар томилогдсон ажлын хэсэг Улаанбаатар радио”ХХК-ийн эзэмшиж байсан Баруун сэлбэ үйлчилгээний төвийн “Ж” блокийн” барилгыг акт үйлдэн хүлээн авсан.</li> <li>- Нийслэлийн Төр Захиргааны 5 дугаар байранд байрлах нийслэлийн харьяа 4 байгууллагын байр ашиглалт, Ашигт малтмалын газрын Цөмийн болон цацрагийн хэлтэс, БГД-т байрлах МШ-ийн 24-р салбарын гар утасны түрээслэгчид, Ачит гар ӨЭМТ-д байр талбай чөлөөлөх талаар мэдэгдэл хүргүүлэв.</li> </ul>
--	--	--	--	--	---

### **Зорилго 3. Хуулиар олгогдсон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх**

3	Зорилт 3. Хууль, тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллаж, эрх зүйн баримтуудыг шинэчлэн боловсруулна.						
7.	Арга хэмжээ 3.1 Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн зүйл, заалтын хэрэгжилтийг ханган ажиллаж хяналт шинжилгээ үнэлгээ хийж НЭДТ-т тайлагнах		Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	50%	50%	Засгийн газрын 2025 оны 84 дүгээр тогтоолоор баталсан журмын дагуу бодлогын баримт бичиг, байгууллагын тайланд дүн шинжилгээ хийхээр хүлээгдэж байна.	-
8.	Арга хэмжээ 3.2 Хяналт шалгалтын байгууллага, дээд байгууллагаас ирүүлсэн зөвлөмж, албан даалгаврын хэрэгжилтийг ханган ажиллах		Ирүүлсэн зөвлөмжийн тоо, хэрэгжилтийн хувь	-	50%	НӨХГ-ын даргын 2025.04.22-ны өдрийн А/43 дугаар тушаалаар байгуулсан ажлын хэсэгт ажиллан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын засаглалын төлөв байдлын үнэлгээ”-г байгууллага дотооддоо үнэлгээг зохион байгуулах ажлын удирдамжийн дагуу байгууллагын засаг төлөв байдлын үнэлгээг үнэн зөв, бодит мэдээлэл цуглуулан, холбогдох баримтууд, мэдээллийг судалж дүн шинжилгээ хийн, судалгаа, холбогдох дүрэм журмын хэрэгжилтийн байдалд тулгуурлан <a href="http://www.moontra.com">www.moontra.com</a> үнэлгээний цахим маягтад 2025.04.25-ны өдөр 126 асуумжийг бөглөн өгсөн.	100%
9.	Арга хэмжээ 3.4 2025 оны нийслэлийн “Бүтээн байгуулалтын жил”-ийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллах		Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	-	50%	Нийслэл хотод хэрэгжүүлэх 24 мега төслийн танилцуулгын хүрээнд “Түгжрэлийг бууруулах ажил”-ын хүрээнд хийгдэх 10 мега төсөл, “Агаарын бохирдлыг бууруулах” ажлын хүрээнд хийгдэх 6 мега төсөл, “Иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх” ажлын хүрээнд хийгдэх 8 мега төслийн танилцуулгын талаар зохион байгуулсан сургалтад хэлтсийн нийт албан хаагчид хамрагдсан.	-
10.	Арга хэмжээ 3.5 Байгууллагын үйл ажиллагаанд MNS ISO 9001:2016		Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	-	50%	НЭДТГ-аас MN ISO 9001:2016 чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх ажилд чиглэл ирүүлээгүй байна.	-

	чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх ажилд оролцох						
11.	Арга хэмжээ 3.6 “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд хавар, намар мод тарих		Модны тоо	27	27	Хэлтсийн албан хаагчид 2025.05.03-ны өдөр Шинэ Налайх цэцэрлэгт хүрээлэнд шинээр 27 хайлаас суулгаж, усалж, арчилснаас гадна өнгөрсөн онуудад суулгаж, ургуулсан мод, бут, сөөгөө усалж арчлах ажилд оролцсон.	100%
12.	Арга хэмжээ 3.7 Байгууллагын “Өмч хамгаалах байнгын зөвлөл”-ийг ажиллуулж байгууллагын эд хөрөнгийн бүртгэл, тооллого, ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулж, хөрөнгийн захиран зарцуулалтад хяналт тавих		Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	50%	50%	ӨХБЗ-ийн 2025 оны 01 дүгээр хуралдаанд оролцон байгууллагын баланст бүртгэлтэй ХУД-ийн Туул тосгонд байрлах “Хар үнэгний аж ахуйн”-ийн барилга, байгууламжийг Нийслэлийн Мал эмнэлгийн газрын, ХУД-ийн 16 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах “Буянт Ухаа 1” 30 айлын орон сууцыг Нийслэлийн орон сууцны корпораци ХК-ийн баланст шилжүүлэх асуудалд санал хүргэсэн.	100%
6	Зорилт 6. Мэдээллийн ил тод байдлыг хангах, мэдээлэл технологийг сайжруулна.						
13.	Арга хэмжээ 6.1 Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын хэрэгжилтийг ханган ажиллах		Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	50%	50%	Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын хэрэгжилтийг ханган ажиллах ажлын хүрээнд хяналт шалгалах явуулж байгаа ажлуудын талаар ЗҮХ-т мэдээлэл хүргүүлсэн	100%
14.	Арга хэмжээ 6.3 Нийслэлийн удирдах ажилтны шуурхай зөвлөгөөний хэрэгжилтийг ханган, биелэлтийг хүргүүлэн, нийт байгууллагын биелэлтийг системээр хянасан. Үүнд:		Үүрэг даалгаврын тоо,	50%	50%	Нийслэлийн удирдах ажилтны шуурхай зөвлөгөөний хэрэгжилтийг ханган, биелэлтийг хүргүүлэн, нийт байгууллагын биелэлтийг системээр хянасан. Үүнд:	100%

	шуурхай зөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллах, хяналт тавих	гүйцэтгэлийн хувь				<ul style="list-style-type: none"> <li>- УАУЭСК-ийн өнөөгийн нөхцөл байдлын талаар мэдээллийг НЭДТГ-т хургуулэн олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр нээлттэй хүргэсэн. Мөн хамгаалалтад авах барилга байгууламж, газрыг хаяг, байршилүүдиг “Цагаан соёот” гэрээт харуул хамгаалалтын албанад хүргэсэн. Тус төвийн ХУД-н Зайсанда байрлах барилга, СХД-ийн 15 дугаар хороонд байрлах Эмнэлгийн төв барилгуудыг чөлөөлөн хөрөнгийг дүүргийн Нэгдсэн эмнэлэгт хүлээлгэн өгөх ажилд хяналт тавьж ажилласан</li> <li>- Нийслэлийн Соёлын төв өргөөний барилгын Г корпуст 550.7 мкө талбай бүхий 23 албаны зориулалттай өрөөг түрээсийн үйл ажиллагаа явуулж байгаа Засгийн газрын харьяа байгууллага, иргэд, аж ахуй нэгж 24 түрээслэгчид нийслэлийн өмчийн байр талбайг 2025 оны 01 дүгээр сарын 10-ны дотор суллаж, хүлээлгэн өгөх тухай мэдэгдэх хуудас хургуулсэн. Бусад 1,784.7 мкө бүхий 73 өрөөг нийслэлийн өмчтэй 6 хуулийн этгээд ашиглаж байна</li> <li>--Нийслэлийн Засаг даргын 2025.01.13-ны өдрийн А/33 дугаар захирамжийн хүрээнд Баянзүрх дүүргийн 8 дугаар хороо, Эрдэнэтолгойн гэр хорооллын 144 айл өрхийн пийшин зуухны галлаганаы аюулгүй байдал, угаарын хий мэдрэгч төхөөрөмжийн хэвийн ажиллагаа, агаар бохирдуулагч гуравдагч эх үүсвэр түлж байгаа эсэхэд хяналт хийж мэдээллийг тухай бүр цахимаар хургуулж ажилласан.</li> </ul>	
7	Зорилт 7. Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллаар хангана.						
15.	Арга хэмжээ 7.3 Албан хаагчийн албан үүргээ мэдлэг ур чадварыг дээшлүүлэх зорилтын хүрээнд зохион байгуулсан сургалт, семинар,	Арга хэмжээний тоо, гүйцэтгэлийн хувь	50%	50%	Дараах сургалт, олон нийтийн арга хэмжээнд албан хаагчид хамрагдсан байна. Үүнд:	100%	
					<ul style="list-style-type: none"> <li>- "Улаанбаатар хот 2040" хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний "14 хот, 3 дагуул хот, 42 хороолол байгуулах шилжилтийн үйл ажиллагааг зохион байгуулах чиг үүргээ бүхийн ажлын хэсгийн хурал",</li> <li>- Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын хяналт шалгалтын хэлтсийн мэргэжилтэнүүдтэй уулзалт, сургалт.</li> </ul>		

	олон нийтийн ажилд оролцох					- -Нийслэлийн онцгой байдлын газраас зохион байгуулсан гамшигийн үеийн сургалт мэдээлэл - -Нийслэлийн өмчийн нэгдсэн программын сургалт. - Төрийн захиргааны удирдах албан хаагчдын сургалт,	
16.	Арга хэмжээ 7.5 Хэлтсийн болон албан хаагчдын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулах, биелэлтийг хугацаанд нь тайлагнах		Нэгж, албан хаагчдын тоо, Гүйцэтгэлийн хувь	50%	50%	Хэлтсийн 2025 оны 19 арга хэмжээ бүхий гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлуулсан. Хэлтсийн төрийн захиргааны 5 албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлан биелэлтийг ханган ажиллаж байна.	100%
9	Зорилт 9. Албан хэрэг хөтлөлтийг зохион байгуулах, баримт бичгийн эмх цэгц, бүрдэл, хадгалалт, ашиглалтыг сайжруулна.						
17	Арга хэмжээ 9.1 Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, холбогдох дүрэм, журам болон стандартыг албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мөрдөн ажиллаж албан бичиг, өргөдөл гомдолыг хугацаанд нь шийдвэрлэх, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх		Албан бичиг, өргөдөл гомдолын тоо, хэрэгжилтийн хувь	243, 100% 33, 100%	50%	ERP-ийн EDoc системээр нийт 45 албан бичиг, 3 өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авч 100% шийдвэрлэсэн.  Тайлант хугацаанд нийт 35 албан бичиг боловсруулан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хүргүүлсэн	100%
18	Арга хэмжээ 9.2 Баримт бичиг нягтлан шалгах комисст ажиллах		Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	-	10%	Газрын даргын 2025 оны тушаалаар байгуулсан комисст 1 албан хаагч орж ажиллаж байна.	100%

19	Арга хэмжээ 9.3 Архивын тухай хууль, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж, байгууллагын архивын сан хөмрөгийг бүрдүүлэх		Архивын нэгжийн тоо	-	3	Үйл ажиллагааны хүрээнд 2024 онд бий болсон хяналт шалгалт, ажлын хэсгийн тайланг акт үйлдэн хүлээлгэн өгсөн.	100%
	Нэмэлт талаар	ажлын	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	-	50%  НЭД-ЫН 2025 ОНЫ ЗАХИРАМЖААР БАЙГУУЛСАН 5 "АЖЛЫН ХЭСЭГ" ОРЖ АЖИЛЛАСАН. ҮҮНД: - A/12 дугаар захирамжаар байгуулсан ажлын хэсэг нь "Эрдэм транс" ХХК-ийн хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийн үнэлгээг хийлгэх ажлыг зохион байгуулж, НЭДТГ, нийслэлийн Нийтийн тээврийн газар, "Гурван ган од" ХХК-тай гэрээ байгуулсан байна. - A/59 дүгээр захирамжаар байгуулсан ажлын хэсэг нь Төслийн нэгжүүдийг нийслэлийн өмчийн байранд байршуулсан ажиллуулах ажлын хүрээнд Соёлын төв өргөөний "А", "Г" хэсгийн 950,03 м.кв талбайг чөлөөлсөн байна - A/127 дүгээр захирамжаар байгуулсан ажлын хэсэг нь НЭДТГ, "Улаанбаатар радио" ХХК-тай 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр 03/127 дугаар "Үл хөдлөх хөрөнгө шилжүүлэх гэрээ" байгуулсан. - Тус гэрээг үндэслэн НӨХГ-ЫН даргын 2025.05.26-ны өдрийн A/85 дугаар тушаалаар байгуулсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн Чингэлтэй дүүргийн 6 дугаар хороонд байрлах Баруунсэлбэ үйлчилгээний төвийн "Ж" блокийн "Улаанбаатар радио" ХХК-ЫН эзэмшиж байсан барилга, эзэмшил газрыг хүлээн актаар хүлээг авсан. - A/264 дүгээр захирамжаар байгуулсан ажлын хэсэг нь 2025.03.13-ны өдөр хуралдан тус "Нью тур	100%

					<p>сафарис" ХХК-ийн эзэмшиж байгаа Соёлын төв өргөөний "В" корпусыг нийслэлийн өмчид буцаан авах асуудлыг судалж компанийн өр төлбөрийн асуудлаар Нийслэлийн Засаг даргад танилцуулахаар шийдвэрлэсэн байна</p> <ul style="list-style-type: none"> <li>- А/307 дугаар захирамжаар байгуулсан ажлын хэсэг нь "Улаанбаатар смарт карт" ХХК-ний төв байр биет хөрөнгө буюу тавилга эд хогшил, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл болон агуулахад хураалттай байсан нийт хөрөнгийг тоолж, тухай бүр лац нааж баталгаажуулан хүлээлгэн өгөхөд бэлтгэсэн. Биет бус хөрөнгийг хүлээн авахад БНСҮ-ын "Ти мони" ХХК-ний инженерүүдийг байлцуулан хүлээн авах санал гарсан тул хөрөнгө хүлээлцэх ажил хойшлогдоод байна.</li> </ul> <p>Байр талбай хүлээлцэх, хяналт хийсэн тухай:</p> <ul style="list-style-type: none"> <li>- БЗД-ийн Шархадны эцсийн буудлын зогсоол дээр байрлах цайны газар, ломбардын байр талбай.</li> <li>- БЗД-ын 14 дүгээр сургуулийн цайны газар, буфетийн талбай</li> <li>- Сонгинохайрхан дүүргийн 32 хороонд байрлах "Олон улсын худалдаа, логистикийн төв" ХК-ийн эзэмшил газрын ашиглалтад</li> <li>- Баянзүрх дүүргийн 127 дугаар сургуулийн цайны газрын гэрээ сунгах хүсэлтийн байр талбай</li> <li>- Баянгол дүүргийн Усан спорт сургалтын төвд түрээсийн гэрээ сунгахгүй болсон нөхцөл байдал болон байр талбай</li> <li>- Зорчигч тээврийн удирдах газрын Шархадны эцсийн буудлын барилга,</li> <li>- Хан-Уул дүүрэгт байрлах 4-р цэцэрлэг,</li> <li>- Сүхбаатар дүүрэгт байрлах Ачит гар ӨЭМТ,</li> <li>- Нийслэлийн Соёлын төв өргөө,</li> <li>- Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хороонд байрлах Лабораторийн барилга</li> <li>- Хан-Уул дүүрэгт байрлах Спортын ордны барилга</li> <li>- Хан-Уул дүүрэгт байрлах ЗДТГ-ын Шинэ Хангарди төвийн барилга</li> </ul>
--	--	--	--	--	---

					<p>- Хүрээ амаржих газрын хуучин барилга</p> <p>Нийслэлийн Засаг даргын 2025.01.13-ны өдрийн А/33 дугаар захирамжийн хүрээнд Баянзүрх дүүргийн 8 дугаар хороо, Эрдэнэтолгойн гэр хорооллын 144 айл өрхийн пийшин зуухны галлагааны аюулгүй байдал, угаарын хий мэдрэгч төхөөрөмжийн хэвийн ажиллагаа, агаар бохирдуулагч гуравдагч эх үүсвэр түлж байгаа эсэхэд хяналт хийж мэдээллийг тухай бүр цахимаар хүргүүлж ажилласан.</p>	
--	--	--	--	--	---	--

Төлөвлөгөөг үнэлсэн:

НӨХГ-ЫН ДАРГА  
(албан тушаал)

Тэмдэг

Төлөвлөгөө тайлагнасан:

ӨХШХ-ИЙН ДАРГЫН АЛБАН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
(албан тушаал) (гарын үсэг)



Төсвийн Шууд захирагч

/В.ОЮУМАА/

.....  
Дорж.ов. 16  
(огноо)

Нэгжийн дарга

/Г.ТЭМҮҮЖИН/

(огноо) 2025.06.16